



# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 09-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот


## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БОЛОН АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ, 2019 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2019 оны 04 сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02, Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталсугай.
2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган хувьцаа эзэмшигчдээс гаргасан санал шүүмжлэл, санаачлагыг үйл ажиллагаандаа тусган зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгасугай.
3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.АЮУШМАА





# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 09-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ, ГИШҮҮДИЙН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, 2019 оны 04 сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэг гишүүний нэг сарын цалин, урамшууллын хэмжээг 350,000 /Гурван зуун тавин мянган/ төгрөгөөр тогтоож, баталсугай.
2. Энэхүү тогтоолыг 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.АЮУШМАА